

ГААЛИЙН АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ, ХАРИЛЦАН
ТУСЛАХ ТЭХЭЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын
Засгийн газар /цаашид "Талууд" гэж нэрлэгдэх/,

Хар тамхитай холбоотой болон гаалийн бусад зөрчлөөс урьд-
чилан сэргийлэх, түүнийг илрүүлэх талаар боломжтой өргөн хүрээнд
хамтран ажиллах хүсэл эрмэлзлэлээ илэрхийлж,

Гаалийн асуудлаар хоёр орны хооронд тогтоосон харилцан
ашигтай хэлхээ холбоог анхааралцаа авч,

Гаалийн байгууллага хоорондын хэлхээ холбоог улам сайж-
руулж хоёр талын уулзалт зөвлөлгөөнийг тогтмолжуулахыг эрмэлзэж,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Тодорхойлолт

Энэхүү Хэлэлцээрийн зорилгод:

а/"Гаалийн байгууллагууд" гэдэгт Монгол Улсын хувьд
- Улсын гаалийн ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын
хувьд - Солонгосын гаалийн газрыг ойлгоно;

б/"Гаалийн хууль" гэдэгт гаалийн байгууллагуудаас
хяналт тавин хэрэгжүүлж байгаа хууль тогтоомжийг ойлгоно;

в/"Зөрчил" гэдэгт гаалийн хуулийг зөрчсөн болон зөрчи-
хийг завдсан аливаа үйлдлийг ойлгоно.

Хоёрдугаар зүйл

Хамтын ажиллагааны хүрээ

Талууд өөрийн орны хууль тогтоомж болон тэдгээрийн гаалийн байгууллагуудын эрх хэмжээний хүрээнд тус тусын гаалийн байгууллагаараа дамжуулан энэхүү хэлэлцээрийн ёсоор:

а/зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөх, таслан зогсоох, гаалийн болон бусад албан татварыг тооцоход тус тусын эрх хэмжээний хүрээнд харилцан туслалцаа үзүүлнэ. Ийнхүү туслалцаа үзүүлэхэд гаалийн хоёр байгууллагад мөрдөж буй хуулийг баримтлах бөгөөд үүнд аливаа этгээдийг баривчлах, саатуулах, нэгжих буюу эд хөрөнгийг нь хураах, саатуулах, эсвэл гаалийн болон бусад татвар, торгууль ногдуулах, бусад хэлбэрээр мөнгөн суутгал авах явдал хамаарахгүй;

б/гаалийн шинэ тогтолцоо, журам судлах, нэвтрүүлэх, туршихад болон хамтын хүчин чармайлт шаардсан цаг үеийн бусад асуудлаар хамтран ажиллана.

Гуравдугаар зүйл

Техникийн хамтын ажиллагаа

Талуудын гаалийн байгууллагууд гаалийн асуудлаар хамтран ажиллахтай холбогдуулан өөр хоорондоо боломжийн хэрээр бүх талын туслалцаа үзүүлнэ. Үүнд:

а/гаалийн техник арга ажиллагааны талаар нарийвчилсан ойлголт авах зорилгоор харилцан ашигтай гэж үзвэл боловсон хүчин солилцох;

б/гаальчдыг сургах, тэдний мэргэшлийг дээшлүүлэхэд туслах;

в/зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх техник хэрэгслийг ашиглах байгаа талаар мэдээлэл, туршлага солилцох;

г/гаалийн асуудлаар болон, түүнчлэн зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх талаар дадлага туршлагатай мэргэжилтэн солилцох;

д/гаалийн хууль, холбогдох бусад дүрэм, журмын талаар мэргэжлийн, судалгааны болон техникийн мэдээлэл, тоо баримт солилцох.

Дөрөвдүгээр зүйл

Мэдээлэл солилцох

Талуудын гаалийн байгууллагууд дор дурдсан зүйлийн талаарх мэдээллийг олж мэдсэн даруйдаа аль болох түргэн хугацаанд нөгөө Талдаа мэдэгцэнэ. Үүнд:

а/нөгөө Талын гаалийн байгууллагын хуульд харш зөрчил гарч болзошгүй нөхцөл байдал;

б/нөгөө Талын гаалийн байгууллагын хуульд харш зөрчлийг таслан зогсооход тус болох хууль сахиулан биелүүлэх арга хэлбэрүүд, ялангуяа, зөрчилтэй тэмцэх тусгай аргууд;

в/зөрчил үйлдэхэд ашиглаж байсан аргууд;

г/хууль сахиулах арга ажиллагааг шинээр амжилттай хэрэгжүүлснээр ажиглаж мэдсэн болон тогтоосон үр дүн;

д/зорчигчид болон ачаанд хяналт шалгалт хийдэг арга ажиллагаа, түүнийг боловсронгуй болгосон байдал;

е/гаалийн нэг байгууллагын харьяалах нутаг дэвсгэрээс гаалийн нөгөө байгууллагын харьяалах нутаг дэвсгэрт нийлүүлэх бараа болон түүнд гаалийн бүрдүүлэлт хийж, нэвтрүүлэх журам;

ж/гаалийн байгууллагуудын харьяалах нутаг дэвсгэрийн хооронд яваа сэжигтэй этгээд, бараа, хөлөг онгоц, автомашин, нисэх онгоцны хөдөлгөөн.

Тавдугаар зүйл

Хүссэн тусламжийн хэлбэр, агуулга

1. Энэхүү зүйлийн 3-т заасныг баримтлан хүсэлтийг бичгээр үйлдэж, түүнтэй холбогдсон бүх бичиг баримтыг хавсаргана.

2. Хүсэлтэд дараах зүйлийг заана. Үүнд:

- а/ хүсэлт гаргасан байгууллагын нэр, хаяг;
- б/ тухайн хүсэлтэд холбогдох хэргийн шинж чанар;
- в/ хүсэлтийн зорилго, хүсэлт тавих шалтгаан;
- г/ хэрэв мэдэгдэж байгаа бол тухайн хүсэлтэд холбогдох байгууллагын нэр, хаяг;
- д/ хүсэлтийн товч утга, хөндөгдсөн эрх зүйн асуудал.

3. Яаралтай хүсэлтийг утсан холбоогоор дамжуулан тавьж болох боловч аман хүсэлтээ бичгээр нэн даруй батална.

Зургадугаар зүйл

Холбоо барих хэлбэр

Энэхүү Хэлэлцээртэй холбогдох аливаа хүсэлтийг гаалийн хоёр байгууллагын дарга нараас тусгайлан томилсон ажилтнаар дамжуулан уламжилна.

Долдугаар зүйл

Туслалцаа үзүүлэхээс татгалзах

1. Тусламж авахаар хүсэлт гаргаж буй гаалийн байгууллагад нийл төрлийн хүсэлт тавихад ямар нэгэн шалтгаанаар түүнийг биелүүлэх боломжгүй бол энэ тухай өөрийн хүсэлтдээ тусгайлан дурдсан байвал зохино. Тухайн хүсэлтийг биелүүлэх эсэхийг хүсэлт хүлээн авсан гаалийн байгууллага шийдвэрлэнэ.

2. Хүсэлт хүлээн авсан гаалийн байгууллага хүсэлтийг биелүүлэх явдал нь тухайн улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал,

нийгмийн бодлогод хохирол учруулж, эсвэл тухайн орны хууль буюу бусад эрхэм дээд ашиг сонирхолд харшилж болзошгүй гэж үзвэл хүсэлтийг бүрэн буюу хэсгийг нь биелүүлэхээс татгалзах, эсвэл тодорхой нөхцөлийг хангаснаар хүсэлтийг биелүүлэхийг шаардаж болно.

Наймдугаар зүйл

Зардал

Өөрөөр заасан ямар нэг хэлэлцээр байхгүй тохиолдолд тусламж хүссэн гаалийн байгууллага нь тусламж үзүүлэхтэй холбогдон гарсан бүх зардлыг хариуцна.

Есдүгээр зүйл

Нууц халгалах

Тавьсан асуулт, өгсөн мэдээллийг тэдгээрийн хэлбэрийг үл харгалзан, Талуудын гаалийн байгууллагын аль нэг нь хүсвэл нууцлан үзэх бөгөөд тийм мэдээлэл, бичиг баримт, бусад зүйлсийг зөвхөн тэдгээрийг дамжуулсан Талын зөвшөөрлөөр өөр зорилгод ашиглаж болно.

Аравдугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох, түүнд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох

1. Энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч /30/ хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд гаалийн байгууллагууд харилцан тохиролцсон дагуу дипломат шугамаар нот бичиг солилцох замаар түүнд өөрчлөлт оруулж болно.

2. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчингүй болгох тухай гаалийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад бичгээр мэдэгдсэнээс хойш 6 сарын дараа хүчингүй болно.

Дээр дурдсан тохиролцоог гэрчилж гарын үсэг зурагсад нь

өөрсдийн Засгийн газраас зохих ёсоор олгосон бүрэн эрхийнхээ дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсгээ зурав.

1993 оны 7 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, солонгос, англи хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд адил хүчинтэй. Хэлэлцээрийг тайлбарлахад санал зөрвөл англи хэл дээрх эх хувийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРААС ЭРХ ОЛГОСНЫ
ДАГУУ

БҮГД НАЙРАМЦАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС
ЭРХ ОЛГОСНЫ ДАГУУ

7/27/93